



**ГАЛТ ТЭРЭГНИЙ
ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН
НЭГДСЭН ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2021 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

Орон тооны бус комисс, зөвлөлийн талаар
авах арга хэмжээний тухай

“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 6.9-д заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. “ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын баталсан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, бүртгэл мэдээллийг боловсронгуй болгох, хийдэл зөрчлийг арилгах, хяналт тавих зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй:

1.1. “ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2017 оны А/62 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн маргаан таслах орон тооны бус комисс”-ын ажил олгогчийг төлөөлж “Хүний нөөцийн мэргэжилтэн” гэснийг “Дотоод үйл ажиллагааны мэргэжилтэн,” гэж, ажилтнуудыг төлөөлж “Дохиолол холбоо, тоног төхөөрөмж хариуцсан мэргэжилтэн” гэснийг “ҮЭХ-ны дарга, суурь бүтэц ашиглалт, объектийн гэрчилгээжүүлэлт хариуцсан ахлах мэргэжилтэн” гэж, “Хөдөлх бүрэлдэхүүний ашиглалт, бүртгэлийн ахлах мэргэжилтэн” гэснийг “ҮЭХ-ны тэргүүлэгч, хүний нөөцийн мэргэжилтэн” гэж тус тус өөрчилсүгэй.

1.2. “ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2017 оны А/63 дугаар тушаалаар баталсан “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн “Дарга: Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга” гэснийг “Дарга: Нягтлан бодогч” гэж, “Дотоод үйл ажиллагааны зохицуулалтын мэргэжилтэн” гэснийг “Дотоод үйл ажиллагааны мэргэжилтэн, нярав” гэж, “Технологи, автоматжуулалт, мэдээллийн ахлах мэргэжилтэн” гэснийг “Програм хангамж, радио зурвас, сүлжээ хариуцсан мэргэжилтэн” гэж, “Тээвэр төлөвлөлт, логистикийн мэргэжилтэн” гэснийг “Хүний нөөцийн мэргэжилтэн” гэж тус тус өөрчилсүгэй.

1.3. “ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2019 оны А/28 дугаар тушаалаар баталсан “Эцэг эхийн зөвлөл”-ийн “Технологи, мэдээлэл, сургалт, судалгааны хэлтсийн дарга” гэснийг “Тээврийн нэгдсэн удирдлага, автоматжуулалт, судалгааны хэлтсийн дарга” гэж, “Автоматжуулалт хариуцсан мэргэжилтэн” гэснийг “Хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн” гэж, “Хөдөлгөөний зурмагийн ахлах шинжээч” гэснийг “Тээврийн нэгдсэн удирдлага, зохицуулалтын ахлах мэргэжилтэн” гэж, “Салбарын судалгааны мэргэжилтэн” гэснийг “Технологи, автоматжуулалт, судалгааны мэргэжилтэн” гэж, “Тээврийн хамтын ажиллагааны мэргэжилтэн” гэснийг “Тээвэр зуучлалын бүртгэл, стандартчилалын мэргэжилтэн” гэж тус тус өөрчилсүгэй.

1.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах болон жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааг хүний нөөцийн мэргэжилтэнд, хэрэглэгчийн эрхийг хамгаалах үйл ажиллагааг статистик мэдээлэл, тээвэрлэлтийн үйл ажиллагааны гэрчилгээжүүлэлт

000763

хариуцсан ахлах мэргэжилтэнд, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг гадаад харилцаа, барилга хариуцсан мэргэжилтэнд тус тус хариуцуулсугай.

2. Тушаалын 1.3-т заасан чиг үүргийг холбогдох ажилтны албан тушаалын тодорхойлолтод нэмэлтээр тусгаж батлуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /И.Банзрагч/-т үүрэг болгосугай.

3. Өмч хамгаалах байнгын зөвлөл, Эцэг эхийн зөвлөл, ХАБЭА, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх комисс, Ёс зүйн зөвлөл, Цалингийн хороо, Захирлын зөвлөл, Баримт бичиг нягтлан шалгах комисс болон хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, хэрэглэгчийн эрхийг хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2021 онд зохион байгуулах ажлыг нэгжийн хагас жилийн ба сарын ажлын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхийг Өмч хамгаалах байнгын зөвлөл /С.Золзаяа/, Ёс зүйн зөвлөл, Эцэг эхийн зөвлөл, Баримт бичиг нягтлан шалгах комисс /Д.Төгсжаргал/, ХАБАЭ-н комисс, Цалингийн хороо /И.Банзрагч/, Захирлын зөвлөл /Д.Пүрэвдолгор/, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах болон жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагаа /М.Оюун-Ундрэм/, хэрэглэгчийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа /Р.Мягмарсүрэн/, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа /Д.Дарьсүрэн/ нарт тус тус даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2017 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн “Ёс зүйн хороо байгуулах тухай” А/22, 2017 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн “Нэмэгдэл олгох тухай” А/42, 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн “Албан тушаалын цалингийн сүлжээ, шатлал шинэчлэн тогтоох тухай” Б/04 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



А.БУЯННЭМЭХ